

"ДУЛААН ШАРЫН ГОЛ "
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах
зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 2.9¹ заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үнэлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2018 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зорилтот түвшинг биелүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /О.Бавуудорж/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


М.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Б.ГАНБАТ

"ДУЛААН ШАРЫН ГОЛ "
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 25

Дугаар № 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хорооны
2018 оны ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1."Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Аудитын хорооны 2018 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үзсүгэй.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хариуцлагатай, үр дүнтэй, санаачилгатай байхыг тухай бүр нь анхааруулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /О.Бавуудорж/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


М.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Б.ГАНБАТ

"ДУЛААН ШАРЫН ГОЛ "
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар № 07

Улаанбаатар хот

2018 оны ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:


1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээр 45,000,000 /Дөчин таван сая/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


M. БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Б. ГАНБАТ

"ДУЛААН ШАРЫН ГОЛ "
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар № 05

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын контрактыг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 2.9¹ дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам"-ын 2.6, 2.7, 2.8, 2.9, 3.4 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 110 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрмийн 8.10.5, 8.10.6 дахь заалт, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын 3.1, 3.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажилласан тул "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны контрактын биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Контрактаар хүлээсэн үүргээ "Хангалттай" биелүүлсэн гүйцэтгэх захирлын контрактыг 1 /нэг/ жилээр сунгахыг Төлөөлөн удирдах зөвлөл /О.Бавуудорж/-д удирдамж болгосугай.

3. Борлуулалтын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, зардал хямдруулах талаар удирдлага зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.


4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга /Л.Нямдорж, Л.Сэлэнгэ/ нарт тус тус үүрэг болгосугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


М.БАТГЭРЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Б.ГАНБАТ